

Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн зарим асуудал

Д.Бямбахүү

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн, цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш, доктрант*

Цагдаагийн албан хаагчид хамаарах ёс зүйн уламжлалын гол сурвалж нь богд Чингис хаан Их Монгол улсыг байгуулж, эмхлэн цэгцэлж гүйцээгээд “Миний хишигтнийг томилоход түмт, мянгат, зуутын ноёдын хөвүүд, сул хүний хөвүүдийн дотроос миний дэргэд тэнцэх билэг эрдэмтэй, бие сайтайг нь ялгаж оруултугай”¹ хэмээн зарлиг болжээ. Энэ нь өнөөгийн цагдаагийн байгууллагад чухал ач холбогдолтой хэвээр байгаа юм. Өнөөдөр цагдаагийн албанд ажилтанг сонгон авахдаа өрөөсгөл байдлаар хандаж байна гэсэн шүүмжлэл байдаг. Зарим тохиолдолд, ялангуяа 90-ээд оны дараа цагдаагийн албанд ажиллах хүн ховор байх үед хүн сонгон авахдаа зөвхөн бие бялдрын үзүүлэлтийг гол болгох тохиолдол гарч байсан билээ. Энэ байдал нь цагдаагийн албаны шаардлагад нийцэхгүй байсан нь практик, бодит байдлаас харагдсан билээ. Нөгөө талаас зөвхөн ёс зүй, боловсролыг дангаар нь гол хүчин зүйл, шалгуур болгож бие бялдрын талыг орхигдуулбаас бас цагдаагийн албаны чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болж чадахгүй. Тиймээс өнөөгийн цагдаагийн албаны боловсон хүчин, хүний нөөцийн бодлогод уг албанд тэнцэх эрдэм, боловсролтой, бие сайтай хүнийг сонгон авах зарчим чухал болж байна. Чингис богдын энэ сургаалыг цагдаагийн албаны хүний нөөцийн бодлогын эрхэм зорилго, гол зарчим болгон тунхаглаж болох юм.

Монголын нууц товчоонд анх дурьдагдсан энэ чухал зарчим нь цаашдаа “Их засаг” хуульд заалт болж орсон байдаг. Тэнд: “Үл харгис, үнэнч шударга, цэгц журамтай, эрдэм гүн, билиг хурц хүмүүсийг эрх биш сайшаан хүндлэх хэрэгтэй бөгөөд зусар, бялдууч, элбэрэл журамгүй этгээдийг эрх биш жигшин занх ёстой” гэжээ. Энэ зарчмын үзэл санаа нь өнөөгийн “Төрийн албаны тухай” хуульд тусгагдсан зарчмуудад тусгасан үзэл санаатай адил байгааг тэмдэглэх хэрэгтэй байна.

Монголын төр, цагдаагийн албаны ёс зүй, эрх зүйн нэг гол сурвалж нь Чингис богдын “Их засаг” хууль байна. “Их засаг” хуулийн 13- р зүйлд “Зарлиг, тушаалыг заавал хичээн гүйцэтгэх хэрэгтэй”² гэж заасан байна. Энэ бол мөн өнөө үед ч төрийн албаны чухал ёс зүйн зарчим, хэм хэмжээ болсоор байгаа билээ. Төрийн алба, түүний дотроос цагдаагийн албаны чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхэд энэ уламжлал бидэнд сайн үлгэр жишээ болох юм.

Мөн хуулийн 18- р зүйлд төрийн алба, цагдаагийн албанд хамаарах маш чухал заалт байсныг дурьдсан байна. Энэ юу гэвэл, “зарлиг зааваргүйгээр эвдлэн шатаах буюу олзлогдогсдыг дураараа шийтгэх, тарчлаан зовоохыг оролдсон тохиолдолд алах ялаар шийтгэнэ” гэжээ. Энэ бол Монголын төрийн албаны ёс

¹Монголын нууц товчоо. УБ. 1976. 184 дэх тал.

²“Их засаг”. 2001. № 2,3.

зүйн гайхамшигт өвийн нэг болж байна. Өнөөгийн цагдаагийн албанд ч маш чухал ач холбогдол бүхий зүйл юм. Өнөөдөр манай улсад хуулийн байгууллагын ажилтнуудыг өөрийн орны иргэдтэй хүнлэг энэрэнгүй хандаж, харилцаж байх тухай асуудлыг ярьж байхад 800 жилийн өмнө Их богд Чингис хаан, Монголчууд маань дайснаа энэрэн хайрлахыг хуульчилж байсан байна.

Одоо төрийн алба хаагч нарын шинэ хэв шинж төлөвших явцад уламжлал, шинэчлэлийн зохистой харьцааг хангахад анхаарах хэрэгтэй бөгөөд үүний утга нь өнгөрсөн, одоо, ирээдүйн хэлхээ холбоог эцсийн дүндээ өнгөрснөөс юу авах, одоо юуг хэрэглэх, ирээдүйд юу өвлүүлэх вэ гэдэгт Монголын гүн ухааны сэтгэлгээг шинэ үеийн шинэлэг сэтгэлгээтэй уялдуулан тусгаж чадваас төрийн алба хаагчийн түүхэн хэв шинж бүрэлдэн, төлөвшин уламжлагдах болно.

Цагдаагийн ёс зүйн тухай ойлголт нь тэдний нийгэмд гүйцэтгэдэг үүрэг, ажил мэргэжлийн онцлогоос хамаарч дэлхийн түвшинд нийтлэг хэм хэмжээгээр тодорхойлогдох мэргэжлийн өвөрмөц ёс зүй болон хөгжиж өөрчлөгдөж байдгаараа онцлог юм. Үүний тодорхой жишээ: НҮБ-ийн ерөнхий ассамблейн 1979 оны 12-р сарын 07-ны өдрийн 34/169 дугаар тогтоолоор баталсан “Хууль хэрэгжүүлэгч албан тушаалтнуудын зан үйлийн тухай” хууль мөрдөж байгаа явдал юм.

Уг Хуульд зааснаар “... цагдаагийн ажилтнууд ... хүмүүсийг хууль бус үйлдлээс хамгаалж хуулиар хүлээлгэсэн үүргээ мэргэжлийн өндөр түвшинд хариуцлагатай биелүүлэх, бүх хүмүүсийн нэр төрийг хүндэтгэн, эрх ашгийг нь хамгаалах, нууц задруулахгүй, харгис хэрцгий хүнлэг бус харьцахгүй үүргийг олон улсын өмнө хүлээсэн байна.”³ Тэгэхээр цагдаагийн ёс зүй нь нийгмийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зэрэг төрийн үүргийг хэрэгжүүлэхдээ олон улсын хэмжээнд тогтсон хэм хэмжээг заавал харгалзан үзэх шаардлагатай.

Өмнөх бичигдэж буй шаардлагууд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2011 оны 598 тоот тушаалаар батлагдсан цагдаагийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, улмаар цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Монгол улсын цагдаагийн албаны тухай хуульд тусгалаа олжээ. Цагдаагийн албан хаагчийн ёс зүй гэдэг нь хүний нэр төр, эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууц задруулахгүй байх, соёлтой, хүлээцтэй, шуурхай ажиллах, мэргэжлийн ур чадвар, улс төрийн мэдрэмж, хуульч ажиллагаа, албаны нэрээр далайлган сүрдүүлэх, хэрцгий хүнлэг бус харьцахыг цээрлэх, өөртөө байгаа өө сэвийг арилгаж төлөвшихийг хэлнэ.

Орчин цагийн шаардлагаас үзвэл Цагдаагийн ёс зүйн онолын тодорхойлолтыг нэг мөр ойлголтод хүргэх асуудал чухал боловч үйлчилгээнд ойртуулан үр өгөөжийг дээшлүүлэх нь зүйтэй гэж үзнэ. Ер нь цагдаагийн ёс зүйн асуудалд шүүмжлэлтэйгээр хандах цаг болжээ. Ёс зүйн хэм хэмжээг амьдралд яв цав хэрэгжүүлнэ гэдэг бол тун ч нарийн төвөгтэй, өөр хоорондоо зөрчилтэй

³ Ц. Цэдэн-Иш. Цагдаагийн албан хаагчийн ёс зүй. УБ. 2004. 31-р тал

хэцүү ажил гэдгийг хэлэхийг хүсч байна. Нөгөө талаас цагдаагийн албан хаагчийн ёс зүй гэдэг нь албаны мэргэжлийн хүлээсэн үүрэгтэй холбогдсон, заавал сахиж биелүүлэх чанартай байдгаараа онцлогтой юм.

Ёс суртахуун нь эрх зүйгээс өмнө үүсч нийгмийн харилцаанд хүчтэй нөлөө үзүүлж ирснээс гадна, эрх зүйгээс хүчтэй бас тогтвортой оршин байдаг түүгээр ч зогсохгүй ёс суртахуун, эрх зүй хоёр бие биеэ нөхөн орлох чанартай байдаг.

“Ёс суртахуун зарим тохиолдолд эрх зүйгээс ч ихээхэн хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэг албадлагагүйгээр өөрсдөө шууд тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршиж” байгаа ажээ.

Цагдаагийн албан хаагчийн ёс зүй хууль биелүүлэх ажилтай шууд холбоотой бөгөөд нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь зөвхөн хуулиар зохицуулагдаж байдаг. Тэгвэл цагдаагийн ёс зүй хүлээсэн үүрэгтэй шууд хамааралтай учир өөр хоорондоо нягт уялдаатай гэдгийг баталж өгнө.

Хэрвээ хууль муу биелүүлж, ёс зүйгээ сахиж чадахгүй бол цагдаагийн байгууллага, албан хаагчийн нэр хүнд өдөр тутам үл үзэгдэх байдлаар алдагдаж, иргэдээс авах туслалцаа хомсдох аюултай гэдгийг хэлэх хэрэгтэй.

Цагдаагийн байгууллага, алба хаагч нарын ажлын онцлог, зарим үүргийг биелүүлэх үед ёс суртахууны уламжлалт хэм хэмжээг умартах үе ч гарна. Жишээ нь: Монгол улсын цагдаагийн албаны тухай хуулийн 33 дүгээр зүйлд заасан: “Цагдаагийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл журмындагуу биеийнхү ч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ.”⁴ гэсэн үүрэг гүйцэтгэх үед ёс зүй бодож байх боломжгүй гэдгийг хууль өөрөө шаардаж байдаг.

Дээрх нөхцөл байдлуудыг цэгцлэн үзвэл:

“Цагдаагийн алба хаагчаас өргөсөн тангарагтаа үнэнч байж хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа эрхэмлэвэл зохих зан үйлийн нийлбэр цогц”-ыг цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ⁵ гэнэ.

Иргэд болон татвар төлөгчдийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудалд шударга, шуурхай хандан, хууль ёс зүйн хэм хэмжээний үндэс болдог.

- Цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа ёс зүйн доорх хэм хэмжээг дагаж мөрдөхийг хууль, эрх зүйн актаар баталгаажуулсан төдийгүй өнөөдөр үндсэн шаардлага нь болж байна.⁶
- Цагдаагийн алба хаагч нь хүний эрх эрх чөлөөг хүндэтгэн хуулийг

⁴<http://legalinfo.mn/law/>.

⁵ Цагдаа сэтгүүл. 2002. № 1. 76-р тал.

⁶ Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн ерөнхий газрын даргын 08 дугаар тушаал, УБ, 2002 он

дээдэлж, шударгаар ажиллах

- Цагдаагийн алба хаагч нь албаны нэр төрийг цэвэр ариун байлгаж, түүний хөгжил бэхжилтэд бодитой хувь нэмэр оруулж ажиллах
- Цагдаагийн алба хаагч нь мэдлэг, боловсрол, сахилга хариуцлага, зан байдлаараа иргэд олон нийтийн хүндэтгэлийг хүлээж ажиллах
- Цагдаагийн алба хаагч нь үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төр, байгууллага, хувь хүний болон албаны нууцыг чанд хадгалж хууль ёсны шийдвэр гаргаагүй байгаа хэрэг, маргааны тухай өөрийн санал бодлыг урьдчилан илэрхийлэх, олон нийтэд мэдээлэх, амлалт өгөхийг хориглох
- Алба хаагч нь цагдаагийн байгууллагын нэгдмэл төвлөрсөн удирдлагын зарчмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, дээд байгууллага, албан тушаалтнаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэрийг ёсчлон биелүүлэхээс гадна нөхдийнхөө албаны ажилд хүндэтгэлтэй хандан тэдний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх
- Цагдаагийн алба хаагч нь албан тушаал, хуулиар олгосон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглах, албан үүргээ биелүүлсэнтэй холбогдуулан шан харамж бэлэг сэлт бусдаас авах, шахаж шаардах, ятгах, зуучлах, хуульд харш болзол тавих, албаны нэрээр түрээ барих, далайлган сүрдүүлэхийг цээрлэх
- Цагдаагийн алба хаагч нь хүнд суртал гаргах, иргэдийг чирэгдүүлэх, хүнлэг бус харьцах, эрх чөлөө, эд хөрөнгөд нь хууль бусаар халдах, танил тал харах, бусдын нөлөөнд автах, хувийн сонирхлоор болон харьяаллын бус хэрэг, маргаанд оролцохыг хориглох
- Цагдаагийн алба хаагч нь боловсрол, мэргэжил, ажлын ур чадвараа байнга дээшлүүлж зан төлвийн муу зуршил, дутагдал гаргахгүй байх
- Цагдаагийн албан хаагч нь гэр бүл, үр хүүхдэдээ халамж анхааралтай байж, ёс суртахууны нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахих мөрдөхийг өөрийн журамт үүргээ гэж үзэх
- Цагдаагийн алба хаагч нь байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, зүйлс, албан хэрэгцээний мэдээ, материал, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахыг цээрлэх⁷
- Цагдаагийн албан хаагчдад тавигдах тодорхой шаардлага нь:
- Цагдаагийн ёс зүй нь уламжлал, шинэчлэл шингэсэн, хууль биелүүлэх ажилтай шууд нөхцөлдсөн, гүйцэтгэж буй үүргийг даган заавал сахигдах учиртай.
- Цагдаагийн ёс зүйн гол үүрэг нь онол номлолыг ажил үйлчилгээнд ойртуулж, үр өгөөжтэй болгоход оршино.
- Цагдаагийн ёс зүйн гол цөм нь шударга байх явдал болно.
- Цагдаагийн ёс зүй ажил, үйлчилгээнд туршигдаж, шинэчлэгдэн баяжна.

⁷ Цагдаа сэтгүүл. 2002. № 1. 77-р тал.

- Цагдаагийн ёс зүйн хэрэгжилтэд иргэдийг өргөн оролцуулах боломжийг бүрдүүлнэ.
- Цагдаагийн ёс зүй нь албан хаагч нарт сурч мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, сахилга баттай байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- Цагдаагийн ёс зүйн зөрчил тэмцлийн үр дүнд сахигдана.
- Цагдаагийн ёс зүйн сахилгыг гол хангагч, хөтөч нь дарга нар бөгөөд биелэлтийг хангана.
- Цагдаагийн ёс зүйг хэрэгжүүлэхийн тулд төв байгууллага ёс зүйн дүрмээ боловсруулж, албад өөрийн онцлогт тохируулан хэрэгжилтийг зохион байгуулна.
- Цагдаагийн ёс зүйн хоёр талын бүрэн зөвшилцөл, итгэлшүүрийн гэрээний үндсэн дээр тэгш байдлаар хэрэгжинэ.
- Цагдаагийн ёс зүйг алба хаагч нар албан тушаал, алдар цолоо үл харгалзан сахиж мөрдөнө.
- Цагдаагийн алба хаагч хүн ёс зүйгээ зөрчиж болох хүнд ба хүндэвтэр ажлуудын жагсаалт, судалгааг гаргаж байнгын анхааралд байлгана.
- Цагдаагийн ёс зүй бие бүрэлдэхүүн, хувь хүний санаачлагад тулгуурлах гэх мэт.

Дээрх нийтлэг ба тодорхой шаардлагууд нь цагдаагийн алба хаагчдын ёс зүйн хэрэгжилтийг хангах чухал нөхцөл болохоос гадна цагдаагийн алба хаагчийн шалгуур болж түүний албаны агуулгыг тодорхойлно.

Цагдаагийн алба төрийн албаны бүрэлдэхүүн болохын хувьд түүний онолын ойлголт шаардлага хэрэгжилт төрийн албаны онол практикийн асуудлаар зохицуулагдах боловч өөрийн онцлогийг агуулсан шинжлэх ухааны судлагдахууныг шаардаж байдаг.

“Цагдаагийн алба хаагчаас өргөсөн тангарагтаа үнэнч байж хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа эрхэмлэвэл зохих зан үйлийн нийлбэр цогцыг цагдаагийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гэнэ”⁸ гэсэн онолын тодорхойлолттой зарчмын хувьд нийлж байна.

Улс оронд нийгмийн дэг журам хангах асуудал нь цагдаагийн байгууллага, албан хаагч бүр сахилга, хариуцлагатай байж төр, засгийн байгууллага, удирдлагаас тогтоосон хууль тогтоомж, шийдвэрийг хэлбэрэлтгүй биелүүлдэг, гэмт хэрэг, зөрчил гаргадаггүй, иргэд олон нийтийн дунд нэр хүндтэй, тэдэнтэй хамтын ажиллагаа сайн байх явдалтай салшгүй холбоотой. Чухамхүү нийгмийн дэг журам хангаснаар иргэд маань айх аюул, айдас түгшүүргүй, амгалан тайван аж төрөх, бүтээн туурвих боломж бүрдэж, энэ үндсэн дээр улс орон, ард иргэд маань хөгжин цэцэглэх үндэс бүрдэх учиртай билээ.

Эрх зүйт төрийн тогтолцоонд хууль.хууль тогтоомжийн ач холбогдол улам нэмэгдэж байгууллага, иргэн бүрээс хуулийг хэлбэрэлтгүй сахин биелүүлэхийг

⁸ Н. Гаравсүрэн. Цагдаагийн албан хаагчийн ёс зүй, түүнийг төлөвшүүлэх асуудал УБ. 2000. 63-р тал.

иргэний ардчилсан нийгэм байгуулж буй өнөө үед чухлаар шаардах боллоо. Энэ нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны байр суурийг тодорхойлох чухал асуудлын нэг юм. Цагдаагийн бүх шатны байгууллага алба хаагч бүр хуулийг дээдлэх, шударга ёсыг дээдлэх, шударга ёс, тэгш байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг барьж ажиллах нь иргэдийн төр засагт болон цагдаагийн байгууллагад итгэх итгэл дээшлэх, тэдгээрийн хамтын ажиллагаа улам сайжрах гол үндэс болно.

Манай улсын цагдаагийн байгууллагын нэр хүнд иргэдийн дунд төдийлөн сайнгүй байгаа нь байгууллагын хариуцлагын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, түүний дотор зарим алба хаагчид иргэдийн хүсэн хүлээсэн хэмжээнд хүрч ажиллахгүй, цагдаагийн үйл ажиллагааг иргэдэд чадварлаг, соёлтой, шуурхай хүргэж чадахгүй, гэмт хэрэг зөрчлийн шинжтэй дуудлагыг хүлээн авмагц шуурхай шийдэхийн оронд хүнд суртал гаргах зэргээр иргэдийг чирэгдүүлдэг явдалтай холбоотой гэж үзэх үндэстэй юм.

Иймд одоогийн мөрдөгдөж байгаа эрх зүйн хүрээнд цагдаагийн байгууллагын хариуцлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэн түүнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна.

Цагдаагийн байгууллагын хариуцлагын тогтолцоо нь түүний бүтэц зохион байгуулалттай салшгүй холбоотой юм. Цагдаагийн байгууллага нь цагдаагийн төв байгууллага, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, харьяа нэгжээс бүрдэнэ..⁹ Цагдаагийн алба, алба хаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуульд зааснаас гадна хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй харилцан хамтран ажиллах, шинжлэх ухаан, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээний ололтыг ашиглах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх үндсэн зарчмыг баримтална¹⁰ Монголын цагдаагийн байгууллагын хэмжээнд хариуцлагын тогтолцоо нь:

- төрийн
- дотоодын
- олон нийтийн хяналт

гэсэн механизмуудаар хэрэгждэг нь зарчмын хувьд хөгжингүй орнуудын цагдаагийн байгууллагын хариуцлагын тогтолцооноос тийм ч ялгаагүй байна. Харин хяналт явуулах цар хүрээ үр нөлөөний хувьд ялгаа байхыг үгүйсгэх аргагүй.

Монголын цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ

⁹Цагдаагийн албаны тухай хууль УБ, 2013, 5 дугаар зүйл

¹⁰Цагдаагийн албаны тухай хууль УБ, 2013, 4 дүгээр зүйл

хэрхэн биелүүлж байгаад хариуцлага тооцохоос гадна төр засгийн байгууллагаас тогтоосон хууль тогтоомжийн хэрэгжилт, цагдаагийн албан хаагчийн ёс суртахууны байдалд хяналт тавьж хариуцлага тооцох тогтолцоо үйлчилж ирсэн.

Цагдаагийн ерөнхий газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж, зэвсэг, техник, хувцас хэрэгсэл, материалаар хангах, боловсон хүчний бодлого боловсруулж алба хаагчдыг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх арга хэмжээг авах, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавих зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж үр дүнг Засгийн газрын өмнө хариуцдаг.

Хууль тогтоомжийн хэрэгжилт, төсөв хөрөнгийн зарцуулалт, алба хаагчдын хариуцлага, сахилгатай холбоотой зарим тулгамдсан асуудлаар Монгол Улсын Их Хурал, Хууль зүй яам, төрийн хяналтын бусад байгууллагаас тусгайлан томилогдсон ажлын хэсэг, комисс хяналт шалгалтыг явуулж үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох тодорхой хугацааны дараа биелэлтийг авч үзэх зэргээр төрийн хяналтыг хэрэгжүүлдэг.

Орон нутгийн төр захиргааны байгууллага нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтийн журмыг бэхжүүлэх, иргэдийн амгалан тайван байдлыг хангуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, түүнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан шийдвэрийн биелэлт үр дүнг тооцож ажилладаг.

Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаа, гэмт хэргийг илрүүлэх замаар зохиож байгаа гүйцэтгэх ажил, захиргааны зөрчлийн шийдвэрлэлтийн явцад хуулийн заалтыг хэрэгжүүлж байгаа байдалд прокурорын байгууллага хяналт тавьдаг.

Хяналтын явцад хуулийн заалтыг илт зөрчсөн тохиолдолд түүнийг засуулах, хариуцлага тооцуулах, процессын тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад мэдэгдэл, даалгавар өгөх замаар хяналтаа хэрэгжүүлдэг.

Эрүүгийн болон захиргааны хэргийг шүүхээр хянан хэлэлцэх явцад хэрэг, зөрчлийг гүйцэд шалгаагүй, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх явцад хуулийн заалтыг ноцтой зөрчсөн зэрэг шүүн таслахад хангалттай үндэслэл бүрдээгүй тохиолдолд шүүх хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагаар нэмэлт ажиллагаа хийлгэхээр хэргийг буцаадаг.

Шүүх, прокурорын хяналтын эдгээр хэлбэр нь цагдаагийн байгууллагын хариуцлагын тогтолцоо бодитой төлөвшихөд тэргүүлэх нөлөө үзүүлдэг.

Цагдаагийн ерөнхий газраас тэдгээртэй үйл ажиллагааны үр дүн, хуулийн хэрэгжилт, сахилга хариуцлагын дүнг үнэлж дүгнэж байх гол арга механизм нь дотоодын хяналт шалгалт байдаг.

Дотоодын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг эрчимжүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилт, алба

хаагчийн сахилга хариуцлага, мэргэжлийн ур чадварыг сайжруулахад ихээхэн үр нөлөөтэй тул ЦЕГ-ын бүтцэд Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын нэгж багтан ажилладаг.

Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлын нэг хэсэг нь сахилга, хариуцлага, ажилтанг ёс суртахууны байдалд чиглэгдэж алба хаагчийн ёс зүйн дүрэм, сахилгын дүрмээр тогтоогдсон хэм хэмжээг хангуулахад төвлөрдөг. Түүнчлэн цагдаагийн алба хаагчийн ёс суртахууны байдалд хяналт тавих үүрэг бүхий " Ёс журам сахиулах хэсэг" -ийг нийслэл хотод 24 цагаар тогтмол ажиллуулж байна.

Манай улсын өнөөгийн практикт иргэд олон нийтээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, шүүмжлэлтэй хандах явдал нь: Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр, иргэдийн өргөдөл, мэдээлэл, санал, гомдол, төрийн бус байгууллагын санал дүгнэлт зэрэг хэлбэрээр илэрхийлэгдэж байна.

Цагдаагийн алба хаагч нь сахилгын болон ёс суртахууны зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх сахилгын хариуцлагыг Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн цагдаагийн алба хаагчид ял шийтгэл хүлээлгэхээргүй бол Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон цагдаагийн албаны ёс зүйн дүрмийг баримтлан сахилгын хариуцлага ногдуулна¹¹.

АНУ, Англи, Умард Ирланд, ХБНГУ-ын цагдаагийн албан хаагчид хүлээлгэх сахилгын шийтгэлийн нэг төрөл нь албанаас түр халах (6 сараас нэг жил хүртэлх хугацаагаар) шийтгэл байдаг. Энэ нь хамт олон болон албаны хүрээллээс тодорхой хугацаагаар гарч өөрийн үйл ажиллагаандаа үнэлэлт дүгнэлт хийн буруутай үйлдлээ ухааран цаашид алдаа дутагдал гаргалгүй ажиллах ёс суртахууны төлөвшил олгоход нөлөөлдөг байна.

Монгол улсын "Төрийн албаны тухай хууль"-ийн 26-р зүйлийн 3-т төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр албанаас халах шийтгэлийн төрлийг багтаасан нь чухал алхам болжээ.¹² Өөрөөр хэлбэл нэг жилийн дараа төрийн албанд ажиллаж болно гэсэн утгатай юм.

Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаад дутагдлаар халагдсан боловч алдаа дутагдалдаа дүгнэлт хийн ухамсарлаж буцаж цагдаагийн байгууллагадаа ажиллах хүсэлтийг зарим халагдсан албан хаагчид гаргадаг ч эрх зүйн зохицуулалтгүйгээс шийдвэрлэх боломжгүй байдаг.

Энэ бүгдээс дүгнэлт хийж цагдаагийн албан хаагчид ноогдуулах ёс зүйн шийтгэл нь дараах хэлбэртэй байхаар хуульчлахыг санал болгож байна.

- Сануулах
- Сарын үндсэн цалинг 20 хүртэлх хувиар 3 сар хүртэлх хугацаагаар хасах

¹¹Цагдаагийн албаны тухай хууль УБ, 2013, 41 дүгээр зүйл

¹²Төрийн албаны тухай хууль УБ, 2002, 26 дугаар зүйл

- Цагдаагийн цолыг бууруулах
- Албанаас 1 жил хүртэлх хугацаагаар халах
- Цагдаагийн албанаас халах

Цагдаагийн алба хаагч нараас гэр бүлийн хүрээнд хэрүүл маргаан гаргах, амралтын цагаар архи ууж согтууран хэвийн бус явах, бусадтай маргах зэрэг зөрчил нэлээд гаргадаг. Энэ төрлийн зөрчил гаргах үедээ цагдаагийн дүрэмт хувцас хэрэглээгүй, албаны нэр бариагүй, алба хаахтай холбоотой зөрчил гаргаагүй тохиолдолд захиргааны эрх зүйн хууль тогтоомжоор шийдвэрлэх ёстой атал сахилгын дүрмээр шийдвэрлэж байгаа нь цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилга ёс зүйн зөрчлийн тоо мэдээ өсөж нийгэмд сөрөг уур амьсгал төрүүлж болох юм.